



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ШИНГЭН ТҮЛШ ШИЛЖҮҮЛЭН АЧИХ БАЙГУУЛАМЖ ТӨААТҮГ-ЫН 2020
ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН
АУДИТ

АУДИТЫН КОД: САГ-2021/19/СТА-ТӨҮГ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх
аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер Д.Энхдалай
Утас: 261885 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn
Аудитор М.Лхагвасүрэн
Утас: 260512 Цахим хаяг: lkhagvasurenm@audit.gov.mn
Аудитыг гүйцэтгэсэн: "Мэжик консалтинг аудит" ХХК
Утас: 70131044 Цахим хаяг: info@magicgroup.mn

Улаанбаатар хот
2021 он

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
УУХҮЯ	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
ҮХХТ	Үл хөдлөх хөрөнгийн татвар
ТЕГ	Татварын Ерөнхий Газар
ТӨААТҮГ	Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТӨБЗГ	Төрийн Өмчийн Бодлого, Зохицуулалтын газар

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	9
3.Аудитын тайлан.....	10
3.1. Ерөнхий зүйл.....	10
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	11
3.4. Материаллаг байдал	11
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	11
3.6. Зорилтот түвшний төлөвлөлт, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	12
3.7. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагаа	13
3.8. Шилэн дансны мэдээлэл.....	13
3.9. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.10. Аудитын илрүүлэлт.....	14
3.11. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	14
4. Менежментийн захидал.....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	16



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ШИНГЭН ТҮЛШ ШИЛЖҮҮЛЭН АЧИХ
БАЙГУУЛАМЖ ТӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Г.ГАНСҮХ ТАНАА

2021.03.15 № 07/912
танай _____ -ны № _____ -г

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ-ын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад, аудит хийлээ.

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ-ын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан материаллаг алдаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 3 арга хэмжээ ажил төлөвлөж хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 151.4 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд хүлээх төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.


Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд бол түүнийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

		/төгрөгөөр/	
Мөрийн дугаар	Үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	3,171,484,081.52	968,684,126.75
1.1.2	Дансны авлага	106,034,478.00	
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	9,720,179.41	159,807,901.61
1.1.4	Бусад авлага		
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		5,054,932,656.98
1.1.6	Бараа материал	170,314,096.50	215,373,672.06
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	11,473,600.00	4,377,272.73
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	3,469,026,435.43	6,403,175,630.13
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	12,837,745,981.81	12,541,898,674.84
1.2.2	Биет бус хөрөнгө	1,442,033,241.51	1,431,920,002.16
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	14,279,779,223.32	13,973,818,677.00
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	17,748,805,658.75	20,376,994,307.13
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	7,122,454.00	2,549,622.00
2.1.1.2	Цалингийн өглөг	282,338.68	
2.1.1.3	Татварын өр	6,344,811.23	8,323,881.87
2.1.1.4	НДШ – ийн өглөг		
2.1.1.5	Богино хугацаат зээл		
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	13,749,603.91	10,873,503.87
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр		107,532,962.97
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн		107,532,962.97
2.2	Өр төлбөрийн нийт дүн	13,749,603.91	118,406,466.84
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	15,362,339,049.32	15,362,339,049.32
2.3.2	Хувийн		
2.3.3	Хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	282,110,305.92	282,110,305.92
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг		
2.3.9	Хуримтлагдсан ашиг	2,090,606,699.6	4,614,138,485.05
2.3.11	Эздийн өмчийн дүн	17,735,056,054.84	20,258,587,840.29
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	17,748,805,658.75	20,376,994,307.13

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Мерийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	3,098,352,100.01	4,310,469,060.05
2	Борлуулалтын өртөг		
3	Нийт ашиг(алдагдал)	3,098,352,100.01	4,310,469,060.05
4	Түрээсийн орлого		
5	Хүүгийн орлого	135,408,678.60	321,415,828.43
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	6,308,500.00	1,500,000.00
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,277,523,267.04	1,534,935,919.13
11	Санхүүгийн зардал	240,000.00	
12	Бусад зардал	7,084,900.00	3,483,560.00
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-14,258,571.81	
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	1,940,962,539.76	3,094,965,409.35
19	Орлогын татварын зардал	196,981,986.71	309,836,540.94
20	Татварын дараах ашиг (алдагдал)	1,743,980,553.05	2,785,128,868.41
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	1,743,980,553.05	2,785,128,868.41
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн	1,743,980,553.05	2,785,128,868.41
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	15,362,339,049.32	282,110,305.92	471,415,994.99	16,115,865,350.23
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				
Залруулсан үлдэгдэл	15,362,339,049.32	282,110,305.92	471,415,994.99	16,115,865,350.23
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			1,743,980,553.05	1,743,980,553.05
Өмчид гарсан өөрчлөлт				
Зарласан ногдол ашиг			-124,789,848.44	-124,789,848.44
2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	15,362,339,049.32	282,110,305.92	2,090,606,699.60	17,735,056,054.84
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				
Залруулсан үлдэгдэл	15,362,339,049.32	282,110,305.92	2,090,606,699.60	17,735,056,054.84
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			2,785,128,868.41	2,785,128,868.41
Зарласан ногдол ашиг			261,597,082.96	261,597,082.96
2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	15,362,339,049.32	282,110,305.92	4,614,138,485.05	20,258,587,840.29

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	/төгрөгөөр/	
		2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	3,311,065,062.59	4,855,308,696.00
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	3,309,126,660.00	4,849,165,981.00
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
	Буцаан авсан албан татвар		
	Татаас, санхүүжилтийн орлого		
	Бусад мөнгөн орлого	1,938,402.59	6,142,715.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,260,929,122.31	1,754,853,416.03
	Ажиллагчдад төлсөн	347,724,377.00	510,023,158.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	90,277,851.14	144,631,155.90
	Бараа материал худалдан авахад төлсөн	151,693,384.33	88,659,716.58
	Ашиглалтын зардалд төлсөн	44,217,990.91	61,136,872.20
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	31,419,410.45	58,034,589.00
	Хүүгийн төлбөрт төлсөн		
	Татварын байгууллагад төлсөн	535,600,750.71	807,356,247.16
	Даатгалын төлбөрт төлсөн	297,360.00	1,347,960.00
	Бусад мөнгөн зарлага	59,697,997.77	83,663,717.19
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	2,050,135,940.28	3,100,455,279.97
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	135,408,678.60	321,415,828.43
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
	Хүлээн авсан хүүгийн орлого	135,408,678.60	321,415,828.43
	Хүлээн авсан ногдол ашиг		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	309,120,235.95	5,363,073,980.21
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	302,630,235.95	241,248,141.41
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	6,490,000.00	66,893,181.82
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		5,054,932,656.98
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-173,711,557.35	-5,041,658,151.78
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	124,789,848.44	261,597,082.96
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
	Төлсөн ногдол ашиг	124,789,848.44	261,597,082.96
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-124,789,848.44	-261,597,082.96
4	Валютын ханшийн зөрүү		
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	1,751,634,534.49	-2,202,799,954.77
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,419,849,547.03	3,171,484,081.52
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн	3,171,484,081.52	968,684,126.75

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ-ын 2020 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

үлдэгдэл

2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2019 он Гүйцэтгэл	2020 он		Зөрүү	Хувь
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт						
	а/ Гол нэр төрлөөр						
1	Шингэн түлш шилжүүлэн ачих	тонн	78,547.7	69,600	117,803	48,203	169.2
	Шингэн түлш хадгалах	тонн	17,916.6	12,727	17,000	4,273	133.6
	Нийт орлого	Төгрөг	2,911,860,800.00	2,248,363,637.0	4,633,384,888.4	2,385,021,251.4	206.1
	Үүнээс:						
2	Цэвэр борлуулалт	Төгрөг	2,775,447,700.00	2,032,363,637.0	4,301,318,060.0	2,268,954,423.0	211.6
	Дансны хүү, ГТБ шинжилгээний орлого	төгрөг	136,383,100.00	216,000,000.0	332,066,828.4	116,066,828.4	153.7
3	Нийт зардал	төгрөг	1,254,256,300.00	1,606,197,789.6	1,538,419,479.1	-67,778,310.5	95.8
4	Татварын өмнөх ашиг	төгрөг	1,657,604,500.00	642,165,847.4	3,094,965,409.3	2,452,799,561.9	481.9
5	Цэвэр ашиг /алдагдал/	төгрөг	1,491,844,100.00	577,949,262.7	2,785,128,868.4	2,207,179,605.7	481.9
	Төсвийн төлбөрт нийт дүн	төгрөг	540,846,100.00	412,118,222.0	951,063,973.1	538,945,751.1	230.8
	а/ Орлогын албан татварт	төгрөг	165,760,500.00	64,216,584.7	331,329,569.6	267,112,984.9	515.9
	б/ НӨАТ	төгрөг	277,547,800.00	203,236,363.0	414,609,992.6	211,373,629.6	204.0
	в/ НДШ	төгрөг	53,601,600.00	84,789,127.0	144,631,155.9	59,842,028.9	170.6
	г/ ХХОАТ	төгрөг	34,345,000.00	49,996,347.3	50,586,913.3	590,566.0	101.2
	д/ ҮХХТ	төгрөг	9,357,400.00	9,600,000.0	9,357,425.7	-242,574.3	97.5
	ж/ Автомашин, тээврийн хэрэгслийн татвар	төгрөг	169,000.00	215,000.0	228,916.0	13,916.0	106.5
	з/ Бусад татвар	төгрөг	64,800.00	64,800.0	320,000.0	255,200.0	493.8
7	Төрийн өмчийн ногдол ашигт	төгрөг	124,789,800.00	223,776,612.9	261,597,083.0	37,820,470.1	116.9
8	Нийт ажиллагсдын тоо	хүн	25	28	32	4	114.3
9	Нийт цалингийн сан	төгрөг	397,051,500.00	584,752,560.0	584,703,097.0	-49,463.0	100.0
10	Борлуулалтын нэг төгрөгт ногдох	төгрөг	0.4	0.7	0.3	-0.4	42.9
11	Хөрөнгө оруулалт	төгрөг	319,948,700.00	326,660,000.0	308,141,323.2	-18,518,676.8	94.3
	Нийт авлага	төгрөг	-	-	159,807,901.6	159,807,901.6	
12	Үүнээс: Найдваргүй	төгрөг	-	-	-	-	
	Нийт өглөг	төгрөг	-	-	10,873,503.9	10,873,503.9	
13	Богино хугацаат	төгрөг	-	-	10,873,503.9	10,873,503.9	
	Урт хугацаат	төгрөг	-	-	107,532,962.9	107,532,962.9	

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасан бүрэн эрхийн хүрээнд Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ-ын 2020 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан, дүгнэлтийг захирал Г.Гансүх танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэлийг сайжруулах талаар өгсөн зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 25-наас 2021 оны 03 дугаар сарын 13-ны хооронд Үндэсний аудитын газрын захиалгаар Мэжик консалтинг аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Мөнхбаяр, аудитын менежер Н.Мөнхзаяа, аудитор Д.Наранбат нар хариуцаж хэрэгжүүлэв.

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ-ын 2020 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 02 дугаар сарын 05-ны өдөр 05 тоот албан бичгээр цахимаар ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар статустай байна. Өмчийн 100 хувийг төр эзэмшиж байна.

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ-ын үйл ажиллагааны эрхэм зорилгыг “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан эрх үүргийн хүрээнд төмөр замаар тээвэрлэн нийлүүлж байгаа газрын тосны бүтээгдэхүүнийг Монголын вагон цистерн болон автоцистернд шилжүүлэн ачих, хадгалах үйл ажиллагааг тасралтгүй, найдвартай явуулах, газрын тосны эх үүсвэрийг нэмэгдүүлэх, цаашид тус байгууламжийн ашиглалтыг мэргэжлийн удирдлагаар хангахад оршино” гэж тодорхойлжээ.

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ-ын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Газрын тосны бүтээгдэхүүнийг шилжүүлэн ачих, хадгалах ажлыг гүйцэтгэх;
- Газрын тосны бүтээгдэхүүнийг шилжүүлэн ачих тээврийн хэрэгслийн бүртгэл, мэдээллээр холбогдох байгууллагыг хангах;
- Олон улсын чанарын стандартад нийцсэн газрын тосны бүтээгдэхүүнийг зохих журмын дагуу импортлох;
- Үйлдвэрийн газар нь хөрөнгө оруулалт хийх, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, судалгаа хийх;
- Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих;
- Хууль, тогтоомжоор хориглоогүй бизнесийн бусад үйл ажиллагаа;
- Бүх төрлийн шатахууны бөөний болон жижиглэн худалдаа эрхлэх,

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 69.6 мянган тонн шатахуун шилжүүлэн ачихаас 117.8 мянган тонныг шилжүүлэн ачиж, 12.7 мянган тонн түлш хадгалахаас 17.0 мянган тонн түлш хадгалж төлөвлөгөөг 151.4 хувиар давуулан биелүүлсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хуульд шимтгэлийн хувь хэмжээнд өөрчлөлт орсныг хэрэгжүүлж ажилласан байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ нь санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Компанийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Тайлант онд тус байгууллагын 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд дээд шатны байгууллагаас дотоод аудит, хяналт шалгалт хийгээгүй байна.

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоосон.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны эхний хагас жилийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын 874.5 сая төгрөгөөс 2 хувиар буюу 17.5 сая төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг тайлант оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн суурь үзүүлэлт нийт зардлын 1,848.3 сая төгрөгөөс 2 хувиар тооцож 37.0 сая төгрөгөөр тогтоолоо.

3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ-ын 2020 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,520.7 сая төгрөгөөр буюу 14.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	3,171.5	968.7	-2,202.8
Бусад санхүүгийн хөрөнгө		5,054.9	5,054.9
Авлага	115.8	159.8	44.0
Урьдчилгаа	11.4	4.4	-7.0
Бараа материал	170.3	215.4	45.1

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ-ын 2020 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Үндсэн хөрөнгө	14,279.8	13,973.8	-306.0
Нийт хөрөнгийн дүн	17,748.8	20,377.0	2,628.2
Өр төлбөр	13.7	118.4	104.7
Эздийн өмч	17,735.1	20,258.6	2,523.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	17,748.8	20,377.0	2,628.2

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, бусад санхүүгийн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, эздийн өмч дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 968.7 сая төгрөг болж 2,202.8 сая төгрөгөөр буурсан нь 3 сараас дээш хугацаатай хадгаламжийг бусад санхүүгийн хөрөнгөөр бүртгэснээс шалтгаалжээ.

Бусад санхүүгийн хөрөнгө дансны үлдэгдэл 5,054.9 сая төгрөг болж өссөн нь арилжааны банканд байршуулсан 1 жилийн хугацаатай хадгаламжаас шалтгаалжээ.

Авлага дансны үлдэгдэл 159.8 сая төгрөг болж 44.0 сая төгрөгөөр өссөн нь Ай си ай си ХХК-аас авах 106.0 сая төгрөгийн авлагыг барагдуулсан, 150.0 сая төгрөгийн татварын авлага нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 215.4 сая төгрөг болж 45.1 сая төгрөгөөр өссөн нь хөдөлмөр хамгааллын материал, багаж хэрэгсэл, засварын материал нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 13,973.8 сая төгрөг болж 306.0 сая төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны элэгдлийн зардлаас шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс нь өөрийн хөрөнгөөр худалдан авсан 308.1 сая төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Өр төлбөрийн дансны үлдэгдэл 118.4 сая төгрөг болж 104.7 сая төгрөгөөр нэмэгдсэн нь дансны өглөг 4.5 сая төгрөгөөр буурч, татварын өр 1.9 сая төгрөгөөр нэмэгдэж, хойшлогдсон татварын өр 107.5 сая төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Эздийн өмч 2,523.5 сая төгрөгөөр өссөн нь тайлан хугацааны үр дүн 2,785.1 сая төгрөгийн ашгийн өсөлт, 261.6 сая төгрөгийн ногдол ашиг зарласан хэмжээгээр буурснаас шалтгаалжээ.

3.6. Зорилтот түвшний төлөвлөлт, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ-ын гүйцэтгэх захирал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 541 дүгээр тогтоолоор Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ-ын 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 2,248.4 сая төгрөгөөр, нийт зардлыг 1,606.2 сая төгрөгөөр, ашгийг 642.2 сая төгрөгөөр тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын 27 арга хэмжээнд 326.7 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 4,633.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 1,848.3 сая төгрөгийн зардал гарган, 2,785.1 сая төгрөгийн ашигтай ажилласан байна. Орлогын эх үүсвэр нь үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос бүрджээ.

Нийт орлогын гүйцэтгэл 4,633.4 сая төгрөг болж төлөвлөснөөс 2,385.0 сая төгрөг буюу 106.08 хувиар давж биелсэн нь газрын тосны бүтээгдэхүүний хадгалалт, шилжүүлэн

ачилт ихээр хийсэн болон Ковид-19 цар тахлын үед үйл ажиллагаа зогсолтгүй явагдаж байсан зэрэг шалтгаанаар голлон нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 1,538.4 сая төгрөг болж, төлөвлөснөөс 67.8 сая төгрөг буюу 4.2 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна. Энэ нь байгаль хамгаалахтай холбоотой зардал, лабораторийн итгэмжлэл, тусгай зөвшөөрөлтэй холбоотой гарах зардал нь санхүү байдлын тайланд биет бус хөрөнгөөр бүртгэгдсэн нь гол нөлөө үзүүлсэн байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 27 нэр төрлийн ажилд өөрийн эх үүсвэрээс цэвэр капиталжсан дүнгээр 308.1 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

ТӨБЗГ-ын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2020 оны улсын төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийн хувь хэмжээг тогтоох шийдвэрийн дагуу тайлант онд 261.6 сая төгрөгийн ногдол ашиг буюу ашгийн 15 хувийг Сангийн яам-д бүрэн төвлөрүүлсэн байна.

3.7. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагаа

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ нь төлөөлөн удирдах зөвлөлгүй байна.

3.8. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд оруулбал зохих 146 мэдээллээс 131 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийн хугацаа болоогүй, 13 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

3.9. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1 акт, 1 албан шаардлага, 4 зөвлөмжийн хэрэгжилт 99.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/сая.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Гүйцэтгэлийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Акт	1	0.3	1	0.3	100.0
Албан шаардлага	1	55.5	1	55.5	100.0
Зөвлөмж	4	15.8	4	15.8	98.0
Нийт дүн	6	71.6	6	71.6	99.0

3.10. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 133.8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 107.5 сая төгрөгийн алдаа зөрчлийг залруулж, 16.7 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 9.6 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Татварын зорилгоор элэгдлийг тооцоолж "санхүүгийн болон орлогын албан татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах тайлан"-д тусгаагүй, хойшлогдсон татварын өр төлбөр 107.5 сая төгрөгийг хүлээн зөвшөөрч бүртгээгүй;

Төлбөрийн акт, албан шаардлага

1. Тайлант онд байгууллагын нэр бүхий 31 ажилтанд 16.7 сая төгрөгийн шагналыг хавтгайруулан олгосон байна. Энэ нь төсвийн тухай хуулийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, үнэн зөв байдал, хэмжилт, үнэлгээ зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлээ.

2. Шилэн дансны нэгдсэн цахим системд 13 мэдээллийг хоцроож байршуулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", гэж заасантай нийцэхгүй байна

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах албан шаардлага хүргүүлээ.

3.11. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Ковид-19 цар тахлын нөхцөл байдлын улмаас аудит хийх цар хүрээ хязгаарлагдаж, үндсэн хөрөнгө, бараа материалд хэсэгчилсэн тооллого хийх биет тест хэрэгжүүлэх ажил хийгээгүй, өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагаатай танилцаагүй тул дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Үндсэн хөрөнгө данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тайлант хугацааны үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг 9.6 сая төгрөгөөр дутуу тооцоолсон байна. Энэ нь Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралт "Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-т "Үндсэн хөрөнгийг ашиглахад бэлэн болсон үеэс буюу түүнийг захиргааны зорилгоор ашиглах нөхцөл хангагдсан үеэс эхлэн элэгдэл тооцно. Үндсэн хөрөнгийн элэгдлийг шулуун шугамын арга, үлдэгдлийг бууруулах арга, бүтээгдэхүүний нэгжийн аргуудаас хөрөнгийн ирээдүйн эдийн засгийн өгөөжид үндэслэн сонгоно; сонгосон аргыг тайлант үе бүрд тогтвортой мөрдөнө.", НБББББ-ийн 4.4 Үндсэн хөрөнгийн бүртгэлд "Шулуун шугамын аргаар жилийн элэгдлийн зардлыг тодорхойлохдоо үндсэн хөрөнгийн элэгдүүлэх хэмжээг ашиглалтын хугацаанд хуваана. Сарын элэгдлийг тодорхойлохдоо жилд ногдох элэгдлийн хэмжээг 12-т хувааж тодорхойлно." гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын оршин байх, үнэн зөв байдал, хэмжилт, үнэлгээ зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Эрсдэл:

Санхүүгийн тайлан болон тайлант үеийн зардал буруу илэрхийлэгдэх;

1.3. Өгсөн зөвлөмж

Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг үнэн, зөв тооцож байх, холбогдох, стандарт, хууль тогтоомж, тушаал шийдвэрийг мөрдөж ажиллах;

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Тус байгууллага асуудлын бүртгэлтэй танилцаж, хариу тайлбарыг ирүүлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2020 он	Аудитын нэр: Аудит	Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ-ийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудит	Аудитын код: САГ-2021/19/СТА-ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын нэр:	Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ		Сая төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Тайлант онд байгууллагын нэр бүхий 31 ажилтанд 16.7 сая төгрөгийн шагналыг хавтгайруулан олгосон байна.	16.7	Албан шаардлага	Захирал Ерөнхий нягтлан	Г.Гансүх Б.Дэлгэрдалай
2	Тайлант хугацааны элэгдлийн зардлыг 9.6 сая төгрөгөөр дутуу тооцоолсон байна.	9.6	Зөвлөмж хүргүүлэх	Захирал Ерөнхий нягтлан	Г.Гансүх Б.Дэлгэрдалай
3	Шилэн дансны нэгдсэн цахим системд 13 мэдээллийг хоцроож байршуулсан байна.		Албан шаардлага	Захирал Ерөнхий нягтлан	Г.Гансүх Б.Дэлгэрдалай
ДҮН		26.3			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 03 дугаар сарын 15

№ 315/СО110025

Улаанбаатар хот

СЭГ- 2021/19/СТА-ТӨМГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн "Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж" ТӨААТҮГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны нэгдсэн цахим системд нийт 146 мэдээлэл байршуулахаас 13 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1.-т "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх;" 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж, мэдээллийг хуулийн хугацаанд ил тод, бүрэн байршуулж, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 6 сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг "Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж" ТӨААТҮГ -ын захирал Г.Гансүх, ерөнхий нягтлан бодогч Б.Дэлгэрдалай нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТОР
МЭЖИК КОНСАЛТИНГ АУДИТ ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

М.ЛХАГВАСҮРЭН

С.МӨНХБАЯР



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 03 дугаар сарын 15

№ 316/СОН0085

Улаанбаатар хот

2021/19/СТА-ТӨЧГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн "Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж" ТӨААТҮГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд байгууллагын нэр бүхий 31 ажилтанд 16,700,000.00 /арван зургаан сая долоон зуун мянган/ төгрөгийн шагналыг хавтгайруулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг зохистой удирдаж, холбогдох хууль журамд заасны дагуу шагнал, урамшууллыг олгож байх, дээрх зөрчлийг арилган албан шаардлагын биелэлтийг 2020 оны 6 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг "Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж" ТӨААТҮГ-ын захирал Г.Гансүх, ерөнхий нягтлан бодогч Б.Дэлгэрдалай нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТОР
МЭЖИК КОНСАЛТИНГ АУДИТ ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

М.ЛХАГВАСҮРЭН

С.МӨНХБАЯР

Утас: +976 51 261585
Факс: +976 11 323266, 324653

Цахим шуудан: info@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

Хаяг: Засгийн газрын IV байр
Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг
Улаанбаатар-15160, Монгол Улс